



ИНД-67

Иргэний Нисэхийн Багц Дүрэм

Эрүүл Мэндийн Стандарт болон Гэрчилгээжүүлэлт

Иргэний нисэхийн ерөнхий газар

ДҮРМИЙН ТАЙЛБАР

ИНД–67 нь:

- нисэх багийн гишүүн болон нислэгийн хөдөлгөөний удирдагч Эрүүл мэндийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргах журам;
- Эрүүл мэндийн гэрчилгээний хүчинтэй байх шаардлага; болон
- нисэх багийн гишүүн, нислэгийн хөдөлгөөний удирдагчид хамааралтай Эрүүл мэндийн стандартыг тогтооно.

Энэ дүрэм нь Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Сайдын баталсан ИНД-67-ийн цахим хувилбар бөгөөд зөвхөн ишлэл хийх зорилгоор хэрэглэнэ. Хүчин төгөлдөр ИНД-67, түүний нэмэлт, өөрчлөлтийн хуулбарыг ИНЕГ-аас, эсхүл www.mcaa.gov.mn веб сайтаас татаж авах боломжтой.

Мэдээлэл

Гишүүн улсуудын иргэний нисэхийн дүрмийг сайжруулах замаар иргэний нисэхийн салбарт нэгдсэн нэг дүрмийн зохицуулалтад шилжих Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-ын 1992 оны 29-р чуулганы А29-3 тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, Монгол Улс болон Шинэ Зеланд улсын ИНЕГ-ын хооронд 1999 оны 05 сарын 06-нд байгуулсан “Техникийн Хамтын Ажиллагааны Санамж Бичиг”-ийг үндэслэн Монгол Улсын Иргэний нисэхийн багц дүрмийг боловсруулсан.

Өөрчлөлтийн түүх**Хүчин төгөлдөр огноо**

Анхны боловсруулалт

2002 оны 02 сарын 01

Нэмэлт, өөрчлөлт 1

2005 оны 09 сарын 14

Нэмэлт, өөрчлөлт 2

2009 оны 09 сарын 16

Нэмэлт, өөрчлөлт 3

2010 оны 05 сарын 07

Нэмэлт, өөрчлөлт 4 (Шинэчлэлт)

... оны ... сарын

Тэмдэглэл: ИНД-67-ийн шинэчлэлтийг англи болон монгол хэл дээр, NZ Part 67 Amend.3-д үндэслэн боловсруулсан болно.

Гарчиг

A Бүлэг – Ерөнхий зүйл	5
67.1 Зорилго.....	5
67.3 Тодорхойлолт	5
67.4 Дүрмийн шаардлагаас чөлөөлөх.....	6
B Бүлэг – Эрүүл мэндийн гэрчилгээжүүлэлт.....	6
67.51 Зорилго.....	6
67.53 Эрүүл мэндийн гэрчилгээний ангилал	6
67.55 Эрүүл мэндийн гэрчилгээ эзэмших хүсэлт	6
67.57 Үзлэгийн дүгнэлт бэлтгэхэд тавих шаардлага	7
67.59 Эрүүл мэндийн үнэлгээний тайлан	7
67.61 Эрүүл мэндийн гэрчилгээний хүчинтэй хугацаа	8
67.63 Итгэмжлэгдсэн эрүүл мэндийн дүгнэлт	9
67.65 Эрүүл мэндийн гэрчилгээг нөхөн олгох.....	9
67.67 Эрүүл мэндийн заавар	9
67.69 Эрүүл мэндийн нууцлал.....	9
C Бүлэг – Эрүүл мэндийн стандарт	10
67.101 Зорилго.....	10
67.103 1-р ангиллын Эрүүл мэндийн гэрчилгээ.....	10
67.105 2-р ангиллын Эрүүл мэндийн гэрчилгээ.....	15
67.107 3-р ангиллын Эрүүл мэндийн гэрчилгээ.....	20
D Бүлэг – Эрүүл мэндийн шалгагч.....	26
67.151 Зорилго.....	26
67.153 Эрүүл мэндийн шалгагчийн гэрчилгээ	26
67.155 Гэрчилгээ эзэмших хүсэлт	26
67.157 Эрүүл мэндийн шалгагчийн гэрчилгээ олгох	26
67.159 Эрүүл мэндийн шалгагчийн гэрчилгээ эзэмшигчийн эрх	27
67.161 Эрүүл мэндийн шалгагчийн гэрчилгээжүүлэлтийн шаардлага.....	27
67.163 Ерөнхий заавар.....	27
E Бүлэг – Эрүүл мэндийн шалгагчийн үйл ажиллагааны шаардлага	29
67.201 Зорилго.....	29
67.203 Байнгын хэрэгжүүлэлт.....	29
F Бүлэг – Даргаас эрх шилжүүлэхэд тавих шаардлага	30
67.251 Зохих ёсоор мэргэшсэн Эрүүл мэндийн шалгагчийг тодорхойлох	30
G Бүлэг – Нисэхийн шалгагч - нөөц.....	30
H Бүлэг – Шилжилтийн зохицуулалт.....	30
67.351 Шилжилтийн зохицуулалт	30
Хавсралт А – Эрүүл мэндийн шалгагчийн ур чадвар.....	32

А Бүлэг – Ерөнхий зүйл

67.1 Зорилго

Энэ Дүрэм нь дараах шаардлагыг тогтооно:

- (1) нисэх багийн гишүүн болон нислэгийн хөдөлгөөний удирдагчид шаардлагатай Эрүүл мэндийн гэрчилгээ (цаашид ЭМГ гэх) олгох болон эзэмших;
- (2) ЭМГ-д тавих эрүүл мэндийн стандартын;
- (3) эрүүл мэндийн шалгагч (цаашид ЭМШ гэх)-ийг гэрчилгээжүүлэх болон үйл ажиллагааны;
- (4) Эрх бүхий байгууллагын ажилтан бус, зохих ёсоор мэргэшсэн ЭМШ-ийг тодорхойлох.

67.3 Тодорхойлолт

(а) Энэ Дүрэмд:

Зүрхний электрон төхөөрөмж гэж биед байршуулах боломжтой, зүрхний хэмнэлийг сайжруулагч автомат төхөөрөмжийг;

Сэтгэцэд нөлөөлөх бодис гэж согтууруулах ундаа, опиоид, каннионид, тайвшруулах, нойрсуулах, кокаин, бусад сэтгэцийн идэвхжүүлэгч, галлюциноген болон дэгдэмхий уусмал, гэхдээ тамхи болон кофе эдгээрт хамаарахгүй;

Үнэмлэх эзэмшигч гэж дараах этгээдийг:

- (1) нисэхийн баримт бичиг эзэмшдэг, эсхүл нисгэгч;
- (2) ЭМГ эзэмшдэг, эсхүл эзэмшихийг дүрмээр шаардсан.

Аливаа холбогдох ерөнхий чиглэлийн хувьд, эрүүл мэндийн нөхцөл нь, хэрэв тухайн ЭМГ-нд хамаарах эрхийг аюулгүй хэрэгжүүлэх, эсхүл тухайн чиг үүргийг аюулгүй гүйцэтгэхэд нөлөөлж байгаа, эсхүл нөлөөлж болзошгүй бол **нисэхийн эрүүл мэндийн онцлох шаардлагад** тооцогдоно;

Эрүүл мэндийн нөхцөлд дараах зүйлүүд багтана:

- (1) их, багаас үл хамааран:
 - (i) аливаа өвчлөл, эсхүл гэмтэл;
 - (ii) бие махбодийн аливаа гажиг, согог, эсхүл чадвар алдалт;
 - (iii) сэтгэцийн аливаа гажиг, согог, эсхүл чадвар алдалт;
 - (iv) энэ зүйлийн (i), (ii), эсхүл (iii)-т заасан бүх төрлийн өвчлөл, гэмтэл, гажиг, согог, эсхүл чадвараа алдсанаас үүдэлтэй аливаа үр дагавар;
- (2) аливаа төрлийн сэтгэцийн байдал, эсхүл зан төлөвийн, эсхүл танин мэдэхүйн эмгэг;
- (3) эмийн бодист донтох, эсхүл түүнээс хамааралтай болох;

- (4) эмэгтэйчүүдийн хувьд, жирэмслэлт болон жирэмслэлтээс, эсхүл жирэмслэлтийг тасалснаас үүдэлтэй бие физиологийн болон сэтгэхүйн өөрчлөлт.

Эрүүл мэндийн заавар гэж нэгтгэсэн эрүүл мэндийн ерөнхий чиглэлийг агуулсан, Даргын гаргасан эрүүл мэндийн заавар;

Эрүүл мэндийн үнэлгээний тайлан гэж 67.59–ийн дагуу Даргын гаргасан тайланг;

(b) Ажил үүрэг гүйцэтгэх чадвараа гэнэт, эсхүл бусад хэлбэрээр алдах шалтгаан болж байгаа, эсхүл шалтгаан болж болзошгүй эрүүл мэндийн нөхцөлийг нисэхийн эрүүл мэндийн онцлох шаардлага (цаашид НЭМОШ гэх)-ын эрүүл мэндийн нөхцөлд тооцно.

67.4 Дүрмийн шаардлагаас чөлөөлөх

(a) Дарга, энэ дүрмийн С Бүлгийн шаардлагаас чөлөөлөхгүй.

(b) Энэ зүйлийн (a) нь хүсэлт гаргагчид энэ дүрмийн дагуу ЭМГ олгохдоо уян хатан шийдвэр гаргах Даргын бүрэн эрхэд нөлөөлөхгүй.

В Бүлэг – Эрүүл мэндийн гэрчилгээжүүлэлт

67.51 Зорилго

Энэ Бүлэг нь дараах шаардлагыг тогтооно:

(a) дараах тохиолдолд шаардагдах маягт болон мэдээллийн:

(1) ЭМГ эзэмших хүсэлт гаргах;

(2) ЭМГ эзэмших хүсэлт гаргагчид үнэлгээ хийх;

(b) ЭМГ-ний ангилал, хүчинтэй хугацаа болон үргэлжлэх хугацааны;

(c) Итгэмжлэгдсэн эрүүл мэндийн дүгнэлт гаргах зорилгоор Даргын хүлээн зөвшөөрөхүйц эксперт- эмчийг тодорхойлох шаардлага болон шалгуурын.

67.53 Эрүүл мэндийн гэрчилгээний ангилал

Дарга энэ Дүрмийн дагуу дараах ангиллын ЭМГ олгоно:

(1) 1-р ангиллын;

(2) 2-р ангиллын;

(3) 3-р ангиллын;

67.55 Эрүүл мэндийн гэрчилгээ эзэмших хүсэлт

ЭМГ эзэмших хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

(1) Даргын тогтоосон холбогдох маягыг бөглөж, зохих төлбөрийн баримтын хамт хүргүүлэх;

- (2) тухайн этгээдийг нотлох дараах аль нэг баримт бичгийг хүргүүлэх:
- (i) хүчинтэй Монгол Улсын иргэний үнэмлэх;
 - (ii) хүчинтэй Жолооны үнэмлэх;
 - (iii) Даргын хүлээн зөвшөөрөхүйц фото зураг бүхий албан ёсны, хүчинтэй бусад бичиг баримт;
- (3) хамааралтай бол, үзлэгт шаардлагатай дараах баримт бичгийг хүргүүлэх:
- (i) ЭМГ шаардсан, тухайн хүсэлт гаргагчийн эзэмшиж буй үнэмлэх;
 - (ii) тухайн хүсэлт гаргагчийн хамгийн сүүлд эзэмшиж байсан ЭМГ;
 - (iii) хамгийн сүүлд гаргасан эрүүл мэндийн үнэлгээний тайлан.
- (4) ЭМГ-ний стандартыг хангаж байгааг тодорхойлох зорилгоор Даргын шаардаж болох, сэтгэцэд нөлөөлөх эмийн бодис, согтууруулах ундаа, төрөл бүрийн эм бэлдмэл хэрэглэснээс үүдэлтэй аливаа хэрэг зөрчилд холбогдож байсан эсэх талаарх мэдээллийг багтаасан, хүсэлт гаргагчийн эрүүл мэндийн нөхцөл, эсхүл түүхтэй холбоотой аливаа мэдээллийг ил болгох, эсхүл ил болгох эрхийг Дарга болон ЭМШ-д олгох.

67.57 Үзлэгийн дүгнэлт бэлтгэхэд тавих шаардлага

Энэ хэсгийн дагуу эрүүл мэндийн үзлэгийн дүгнэлт гаргах зорилгоор, ЭМШ нь:

- (1) дараах үүрэгтэй:
- (i) хүсэлт гаргагчид эрүүл мэндийн ерөнхий үзлэг хийхдээ, хүсэлт гаргасан ЭМГ-нд тавигдах эрүүл мэндийн стандарт болон аливаа холбогдох ерөнхий чиглэлийг харгалзан үзэх;
 - (ii) ерөнхий чиглэлд заасан холбогдох эрүүл мэндийн дүгнэлтийн хуудсыг бөглөх;
- (2) аливаа ерөнхий чиглэлд өөрөөр зааснаас бусад тохиолдолд, энэ дүрмийн дагуу шаардсан аливаа шинжилгээ, үзлэг, эсхүл давтан үзлэгийн хариу нь тухайн шинжилгээ, үзлэг, эсхүл давтан үзлэг хийлгэсэн өдрөөс хойш 90 хоног хэтэрсэн бол түүнд үндэслэн дүгнэлт гаргахгүй байж болно.

67.59 Эрүүл мэндийн үнэлгээний тайлан

Дарга дараах үүрэгтэй:

- (1) **анхаарах шаардлагатай** эрүүл мэндийн нөхцөлийн дэлгэрэнгүйг багтаасан, ЭМГ эзэмших хүсэлтэд хийсэн үнэлгээ болон, хэрэв ЭМГ олгосон бол, тухайн ЭМГ-нд заасан байнгын хяналтын шаардлага болон заасан тэмдэглэлийг Ерөнхий чиглэлд тодорхойлсон хэлбэрээр үнэлгээний тайланд тэмдэглэх;
- (2) хувийг тухайн хүсэлт гаргагчид хүргүүлэх.

67.61 Эрүүл мэндийн гэрчилгээний хүчинтэй хугацаа

(a) Энэ зүйлийн (c) болон (e)–г харгалзан, Дарга ЭМГ-г дараах хугацаагаар олгож болно:

(1) 1-р ангиллын ЭМГ:

- (i) 6 сар хүртэлх хугацаагаар, ганц нисгэгчтэй зорчигч тээвэрлэх арилжааны нислэгийн хувьд, хэрэв хүсэлт гаргагч нь ЭМГ олгох үед 40 болон түүнээс дээш настай бол; эсхүл
- (ii) 12 сар хүртэлх хугацаагаар, бусад бүх тохиолдолд;

(2) 2-р ангиллын ЭМГ:

- (i) 60 сар хүртэлх хугацаагаар, хэрэв ЭМГ олгох үед хүсэлт гаргагч нь 40-өөс доош настай бол; эсхүл
- (ii) 24 сар хүртэлх хугацаагаар, хэрэв ЭМГ олгох үед хүсэлт гаргагч нь 40 болон түүнээс дээш настай бол;

(3) 3-р ангиллын ЭМГ:

- (i) 48 хүртэлх сарын хугацаагаар, хэрэв ЭМГ олгох үед хүсэлт гаргагч нь 40-өөс доош настай бол; эсхүл
- (ii) 24 сар хүртэлх хугацаагаар, хэрэв ЭМГ олгох үед хүсэлт гаргагч нь 40 болон түүнээс дээш настай бол.

(b) Энэ зүйлийн (a)-ийн дагуу олгосон ЭМГ нь:

- (1) зөвхөн олгогдсон өдрөөс эхлэн хүчинтэй болно;
- (2) дараахаас бусад тохиолдолд, хүчинтэй хугацаа дуусах хүртэл хүчинтэй хэвээр байна:
 - (i) ЭМГ хураагдсан; эсхүл
 - (ii) тухайн эзэмшигч дараагийн, эсхүл нөхөн олгосон ЭМГ авсан.

(c) Хэрэв шинээр ЭМГ олгох үед хүсэлт гаргагчийн хүчинтэй ЭМГ-ний хугацаа 30, эсхүл түүнээс доош хоногийн хугацаанд хүчинтэй хэвээр байгаа бол, Дарга шинэ ЭМГ-ийг энэ зүйлийн (a)-д зааснаас урт, өмнөх ЭМГ-ний дуусах хугацаатай ижил хугацаагаар олгож болно.

(d) Энэ зүйлийн (c) нь зөвхөн дараах тохиолдолд үйлчилнэ, хэрэв:

- (1) Дарга тухайн хүсэлт гаргагч нь энэ зүйлийн (a)–ийн дагуу зөвшөөрсөн хамгийн урт хугацаагаар шинэ ЭМГ эзэмших шалгуурыг хангаж байгааг тогтоосон бол;
- (2) Дарга өмнөх гэрчилгээний дуусах хугацааг 60–аас дээш хоногоор сунгаагүй бол.

(e) Дарга, тухайн ЭМГ олгох үед 40, эсхүл түүнээс дээш настай байгаа хүсэлт гаргагчид энэ зүйлийн (a)–д заасны дагуу 1-р ангиллын ЭМГ олгохдоо энэ зүйлийн (a)(1)(i)-д заасан нэг бүтэн хугацаа болон (a)(1)(ii)-т заасан нэг бүтэн хугацаагаар олгож болно.

67.63 Итгэмжлэгдсэн эрүүл мэндийн дүгнэлт

Итгэмжлэгдсэн эрүүл мэндийн дүгнэлт гаргах зорилгоор эксперт-эмчийг хүлээн зөвшөөрөхүйц гэж тодорхойлохын өмнө Дарга дараах шаардлага хангасан болохыг бататгах ёстой:

- (1) тухайн эксперт-эмч нь эмчлэгч эмч болохыг;
- (2) тухайн эксперт-эмч нь дараах байгууллагад ажиллаж, шаардлагатай түвшинд мэргэшсэн ба туршлагатай болохыг:
 - (i) нисэхийн анагаах ухааны; эсхүл
 - (ii) тодорхой нөхцөлд, хэрэв Дарга анхаарах шаардлагатай гэж үзвэл, итгэмжлэгдсэн эрүүл мэндийн дүгнэлт гаргадаг эмнэлгийн салбарт.

67.65 Эрүүл мэндийн гэрчилгээг нөхөн олгох

(a) ЭМГ эзэмшдэг этгээд нь дараах тохиолдолд гэрчилгээг нөхөн авах тухай хүсэлтээ Даргад бичгээр гаргаж болно, хэрэв тухайн гэрчилгээг:

- (1) гээгдүүлсэн, алдсан, эсхүл гэмтээсэн бол; эсхүл
- (2) гэрчилгээн дээрх мэдээлэл уншигдах боломжгүй гэмтсэн бол.

(b) Гэрчилгээ нөхөн олгох хүсэлт гаргагч нь зохих төлбөрийн баримтыг дараах баримтын хамт Даргад хүргүүлэх үүрэгтэй:

- (1) ЭМГ-г алдсан, үрэгдүүлсэн, эсхүл гэмтээсэн тухай албан ёсны мэдүүлэг; эсхүл
- (2) тухайн гэмтсэн гэрчилгээ.

67.67 Эрүүл мэндийн заавар

Дарга, аливаа гаргасан ерөнхий чиглэл болон ЭМГ-ний хүсэлт гаргахад анхаарах мэдээллийг багтаасан эрүүл мэндийн заавар гаргах үүрэгтэй ба эмчилгээ, захиргаа болон эрх зүйн холбогдох мэдээлэл, зөвлөмж, гарын авлага материалыг багтаасан байна.

67.69 Эрүүл мэндийн нууцлал

Энэ дүрэм нь Хувь хүний нууцын тухай хуулийн аливаа зүйл заалтыг сулруулах, үгүйсгэх утга санааг агуулаагүй болно.

С Бүлэг – Эрүүл мэндийн стандарт

67.101 Зорилго

Энэ бүлэг нь ЭМГ-ний стандартыг тогтооно.

67.103 1-р ангиллын Эрүүл мэндийн гэрчилгээ

(a) Энэ зүйлийн (b)–ээс (m)-д заасан стандартыг хангаж байгаа хүсэлт гаргагчийг 1-р ангиллын ЭМГ-ний стандарт хангасанд тооцно.

Ерөнхий шаардлага

(b) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах эрүүл мэндийн нөхцөлгүй байх;
- (2) энэ зүйлийн (b)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн аливаа онош, эсхүл түүхгүй байх:
 - (i) хэвийн бус байдал;
 - (ii) хөгжлийн бэрхшээлтэй, эсхүл өвчтэй (идэвхтэй, эсхүл нуугдмал);
 - (iii) осол, гэмтэл, эсхүл мэс заслын үр дагавар;
 - (iv) физиологийн, эсхүл эмгэг зүйн явц;
 - (v) хорт хавдрын явц;
 - (vi) ядаргаа үүсгэх нөхцөл;
 - (vii) тохирох эмчилгээ, эсхүл эмчилгээний арга, эсхүл аль аль нь тодорхойгоос бусад халдвар;
- (3) аливаа холбогдох ерөнхий чиглэлийн хувьд, 1–р ангиллын ЭМГ-д хамаарах эрхийг аюулгүй хэрэгжүүлэх, эсхүл тухайн ажил үүргийг аюулгүй гүйцэтгэхэд нөлөөлж байгаа, эсхүл нөлөөлж болзошгүй дараах нөхцөлгүй байх:
 - (i) аливаа эм, эмийн бодис, эмийн бэлдмэл хэрэглэдэг, эсхүл тухайн цаг хугацаанд эмчилгээнд бэлдэж байгаа, эсхүл хийлгэж байгаа; эсхүл
 - (ii) аливаа эм, эмийн бодис, эмийн бэлдмэл, эмчилгээний бэлтгэл, эсхүл эмчилгээнээс үүдэлтэй аливаа гаж нөлөөнд орсон.

Мэдрэлийн Эрхтэн тогтолцоо

(c) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах аливаа мэдрэлийн, мэдрэлийн мэс заслын, сэтгэцийн, эсхүл сэтгэл зүйн нөхцөлийн, эсхүл зан төлөвийн, эсхүл танин мэдэхүйн эмгэгийн онош, эсхүл түүхгүй байх;

- (2) энэ зүйлийн (c)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн аливаа онош, эсхүл түүхгүй байх:
- (i) мэдрэлийн эрхтэн тогтолцооны аливаа бүрэлдэхүүн хэсгийн өвчин, эсхүл эмгэг;
 - (ii) мигрень /толгой таллаж өвдөх/, эсхүл бусад хүнд хэлбэрийн толгойн өвчин;
 - (iii) сэтгэхүйн, эсхүл үйл хөдлөлийн хэвийн бус байдал;
 - (iv) сэтгэцийн өөрчлөлтийн нөхцөл;
 - (v) солиорол;
 - (vi) зан чанарын эмгэг;
 - (vii) сэтгэцийн хэвийн бус байдал, эсхүл невроз;
 - (viii) сэтгэл гутрал;
 - (ix) бэртлийн дараах стрессийн эмгэг;
 - (x) мэдрэлийн мэс засал, эсхүл тархины гэмтлийн үр дагавар;
- (3) энэ зүйлийн (c)(1)–ээр хязгаарлахгүйгээр, татаж унадаг өвчний, эсхүл түүнээс үүдэлтэй таталт өгдөг эрсдэл ихэссэнтэй холбоотой бусад нөхцөлийн онош, эсхүл түүхгүй байх;
- (4) аливаа холбогдох ерөнхий чиглэлийн хувьд, 1–р ангиллын ЭМГ-д хамаарах эрхийг аюулгүй хэрэгжүүлэх, эсхүл тухайн ажил үүргийг аюулгүй гүйцэтгэхэд нөлөөлж байгаа, эсхүл нөлөөлж болзошгүй сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэдэг онош, эсхүл өвчний түүхгүй байх;
- (5) аливаа холбогдох ерөнхий чиглэлийн хувьд, 1–р ангиллын ЭМГ-д хамаарах эрхийг аюулгүй хэрэгжүүлэх, эсхүл тухайн ажил үүргийг аюулгүй гүйцэтгэхэд нөлөөлж байгаа, эсхүл нөлөөлж болзошгүй сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэдэггүй байх.

Зүрх судасны эрхтэн тогтолцоо

(d) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах зүрх судасны, эсхүл цусны эргэлтийн эрхтэн тогтолцооны аливаа нөхцөлийн онош, эсхүл түүхгүй байх;
- (2) энэ зүйлийн (d)(1)–ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн аливаа онош, эсхүл түүхгүй байх:
 - (i) зүрхний титэм судасны өвчин;
 - (ii) зүүн багцын салааны хориг;
 - (iii) ишемигийн шалтгааныг арилгаснаас бусад, баруун багцын салааны хориг;
 - (iv) цусны даралт тогтворгүй ихсэх;

- (v) зүрхний булчингийн, хавхлагын, эсхүл дамжуулах тогтолцооны хэвийн бус байдал;
- (vi) зүрхний хэмнэлийн хэвийн бус байдал;
- (3) энэ зүйлийн (d)(1)–ээр хязгаарлахгүйгээр, зүрхний электрон төхөөрөмж шаарддаг эмгэггүй байх;
- (4) зүрхний булчингийн перфузийн үйл ажиллагаанаас бусад, зүрх судасны өвчний эрсдэлт хүчин зүйлгүй байх.

Амьсгалын эрхтэн тогтолцоо

(e) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй :

- (1) НЭМОШ-д хамаарах амьсгалын замын эрхтэн тогтолцооны аливаа нөхцөлийн онош, эсхүл түүхгүй байх;
- (2) энэ зүйлийн (e)(1)–ээр хязгаарлахгүйгээр, зөвхөн урьдчилан сэргийлэх зорилгоор кортикостероид эмчилгээ хэрэглэдэг, тогтмол хяналтад байдгаас бусад тохиолдолд, НЭМОШ-д хүргэж болох гуурсан хоолойн багтраа өвчний онош, эсхүл түүхгүй байх.

Хоол боловсруулах болон дотоод шүүрлийн булчирхайн эрхтэн тогтолцоо

(f) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах хоол боловсруулах, эсхүл дотоод шүүрлийн булчирхайн эрхтэн тогтолцооны аливаа нөхцөлийн онош, эсхүл түүхгүй байх;
- (2) энэ зүйлийн (f)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн аливаа онош, эсхүл түүхгүй байх:
 - (i) хоол боловсруулах эрхтэн, эсхүл түүний дайвар эрхтний хэвийн бус байдал, өвчин, эсхүл эмгэг явц;
 - (ii) хоол боловсруулах эрхтэн, эсхүл түүний дайвар эрхтний өвчин, эсхүл бэртэл, эсхүл мэс заслын үр дагавар;
 - (iii) энэ хэсгийн (3)-т зааснаас бусад, бодисын солилцоо, хоол тэжээл, эсхүл дотоод шүүрлийн булчирхайн эмгэг;
- (3) энэ зүйлийн (f)(1)-ээр хязгаарлахгүйгээр, дараахаас бусад тохиолдолд, чихрийн шижин, эсхүл хэвийн бус глюкозын ямар ч шинж тэмдгийн онош, эсхүл түүхгүй байх:
 - (i) чихрийн шижингийн эсрэг аливаа эмийн бодис хэрэглэхгүйгээр, тухайн нөхцөл байдлыг хангалттай түвшинд хянадаг бол; эсхүл
 - (ii) хэрэв тухайн нөхцөл байдлыг хянахын тулд чихрийн шижингийн эсрэг эмийн бодис хэрэглэдэг бол:
 - (iia) тухайн нөхцөл байдал нь эмчийн тогтмол үзлэг, хяналтад байх;
 - (iib) инсулин хэрэглэдэггүй байх;
 - (iic) аливаа холбогдох ерөнхий чиглэлийн хувьд, уудаг эмийн бодисыг дангаар болон хавсран хэрэглэх нь 1–р ангиллын ЭМГ–нд хамаарах

эрх, үүргээ аюулгүй хэрэгжүүлэхэд нөлөөлөхгүй болон бараг нөлөөлөхгүй байх.

Цус болон дархлааны эрхтэн тогтолцоо

(g) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах цус болон дархлааны эрхтэн тогтолцооны аливаа өвчний онош, эсхүл түүхгүй байх;
- (2) энэ зүйлийн (g)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн аливаа онош, эсхүл түүхгүй байх:
 - (i) цус төлжүүлэлт /миелопролифератив/ болон халдварын шалтгааныг арилгаснаас бусад, дэлүү томрох;
 - (ii) тодорхой хэсгийн, эсхүл бүх биеийн тунгалгийн булчирхай томрох;
 - (iii) цусны өвчин, эсхүл цус, эсхүл түүний бүрдэл хэсгийн өвчний нөхцөл байдал;
 - (iv) дархлаа сулрах, эсхүл хэт идэвхжихтэй холбоотой эмгэг, эсхүл нөхцөл байдал.

Шээс - бэлгийн замын эрхтэн тогтолцоо

(h) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах шээс-бэлгийн замын эрхтэн тогтолцооны аливаа нөхцөлийн онош, эсхүл түүхгүй байх;
- (2) энэ зүйлийн (h)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн аливаа онош, эсхүл түүхгүй байх:
 - (i) шээс-бэлгийн замын эрхтэн тогтолцооны хэвийн бус байдал, эсхүл өвчин;
 - (ii) шээс-бэлгийн замын өвчин, эсхүл бэртэл, эсхүл мэс заслын үр дагавар;
 - (iii) бөөр, эсхүл шээсний зам бөглөрсөн, эсхүл бөглөрөх эрсдэл ихэссэн.

Нөхөн үржихүйн эрхтэн тогтолцоо

(i) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах нөхөн үржихүйн эрхтэн тогтолцооны аливаа нөхцөлийн онош, эсхүл түүхгүй байх;
- (2) энэ зүйлийн (i)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн аливаа онош, эсхүл түүхгүй байх:
 - (i) сарын тэмдгийн мөчлөгийн алдагдал;
 - (ii) жирэмслэлт.

Яс- булчингийн эрхтэн тогтолцоо

(j) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах яс–булчингийн эрхтэн тогтолцооны аливаа нөхцөлийн онош, эсхүл түүхгүй байх;
- (2) энэ зүйлийн (j)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн аливаа онош, эсхүл түүхгүй байх:
 - (i) арьс, холбогч эд, яс, үе мөч, булчин, шөрмөс эсхүл булчин-шөрмөсний хэвийн бус байдал, өвчин, эсхүл эмгэг явц;
 - (ii) арьс, холбогч эд, яс, үе мөч, булчин, шөрмөс эсхүл булчин шөрмөсний өвчин, эсхүл бэртэл, эсхүл мэс заслын үр дагавар.

Чих, хамар, хоолойн эрхтэн тогтолцоо

(k) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах чих, хамар, хоолойн эрхтэн тогтолцооны аливаа нөхцөлийн онош, эсхүл түүхгүй байх;
- (2) энэ зүйлийн (k)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн аливаа онош, эсхүл түүхгүй байх:
 - (i) гадна, дунд, эсхүл дотор чихний хэвийн бус байдал, өвчин, эсхүл эмгэг явц;
 - (ii) шүд, ам, эсхүл амьсгалын дээд замын хэвийн бус байдал, өвчин, эсхүл эмгэг явц;
 - (iii) евстахиевийн сувгийн битүүрэл, эсхүл дунд чихний хэвийн бус байдал;
 - (iv) тэнцвэрийн эрхтэн тогтолцооны хэвийн бус байдал.

Сонсгол

(l) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах аливаа сонсголын эмгэгийн онош, эсхүл түүхгүй байх;
- (2) энэ зүйлийн (l)(1)-ээр хязгаарлахгүйгээр, аль ч чихний сонсох чадварын дутагдал нь дараахаас хэтэрсэн онош, эсхүл түүхгүй байх:
 - (i) 500, 1000, 2000 Гц-ийн давтамж тус бүрт 35 дБ; эсхүл
 - (ii) НЭМОШ-д хүргэж болох 3000 Гц-ийн давтамжид 50 дБ.

Хараа

(m) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах аливаа харааны эмгэгийн онош, эсхүл түүхгүй байх;

- (2) энэ зүйлийн (m)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн аливаа онош, эсхүл түүхгүй байх:
- (i) нүд, эсхүл түүний дайврын хэвийн бус байдал, өвчин, эсхүл эмгэг явц;
 - (ii) нүд, эсхүл түүний дайврын өвчин, эсхүл бэртэл, эсхүл мэс заслын үр дагавар;
 - (iii) харааны талбайн, эсхүл хос харааны үзүүлэлтүүдийн хэвийн бус байдал;
 - (iv) мэс заслаас үүдэлтэй аль нэг нүдний харааны хугарлын өөрчлөлт;
- (3) энэ зүйлийн (m)(1)-ээр хязгаарлахгүйгээр, холын хараа нь хоёр нүдэнд тус тусдаа шилтэй, эсхүл шилгүй 6/9, эсхүл илүү харах болон хос хараа нь 6/6, эсхүл илүү харах;
- (4) энэ зүйлийн (m)(1)-ээр хязгаарлахгүйгээр, ойрын хараа нь шилтэй, эсхүл шилгүйгээр N5-ын дүрсийг, эсхүл хос хараагаар 30-50 см-ийн хоорондох зайнаас илүү харах болон дундын хараа нь N14 дүрсийг, эсхүл хос хараагаар 1 м-ийн зайнаас илүү харах;
- (5) энэ зүйлийн (m)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох өнгө ялгах чадварын дутагдал илрээгүй байх.

67.105 2-р ангиллын Эрүүл мэндийн гэрчилгээ

(a) Энэ зүйлийн (b)-ээс (m)-д заасан стандартыг хангаж буй хүсэлт гаргагчийг 2-р ангиллын ЭМГ-ний стандартыг хангасанд тооцно.

Ерөнхий шаардлага

(b) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах эрүүл мэндийн нөхцөлгүй байх;
- (2) энэ зүйлийн (b)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн аливаа онош, эсхүл түүхгүй байх:
 - (i) хэвийн бус байдал;
 - (ii) хөгжлийн бэрхшээлтэй, эсхүл өвчтэй (идэвхтэй, эсхүл нуугдмал);
 - (iii) осол, гэмтэл, эсхүл мэс заслын үр дагавар;
 - (iv) физиологийн, эсхүл эмгэг зүйн явц;
 - (v) хорт хавдрын явц;
 - (vi) ядаргаа үүсгэх нөхцөл;
 - (vii) тохирох эмчилгээ, эсхүл эмчилгээний арга, эсхүл аль аль нь тодорхойгоос бусад халдвар;
- (3) аливаа холбогдох ерөнхий чиглэлийн хувьд, 2-р ангиллын ЭМГ-д хамаарах эрхийг аюулгүй хэрэгжүүлэх, эсхүл тухайн ажил үүргийг аюулгүй гүйцэтгэхэд нөлөөлж байгаа, эсхүл нөлөөлж болзошгүй дараах нөхцөлгүй байх:

- (i) аливаа эм, эмийн бодис, эмийн бэлдмэл хэрэглэдэг, эсхүл тухайн цаг хугацаанд эмчилгээнд бэлдэж байгаа, эсхүл хийлгэж байгаа; эсхүл
- (ii) аливаа эм, эмийн бодис, эмийн бэлдмэл, эсхүл эмчилгээний бэлтгэл, эсхүл эмчилгээнээс үүдэлтэй аливаа гаж нөлөөнд орсон.

Мэдрэлийн эрхтэн тогтолцоо

(c) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах аливаа мэдрэлийн, мэдрэлийн мэс заслын, сэтгэцийн, эсхүл сэтгэл зүйн нөхцөлийн, эсхүл зан төлөвийн, эсхүл танин мэдэхүйн эмгэгийн онош, эсхүл түүхгүй байх;
- (2) энэ зүйлийн (c)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн аливаа онош, эсхүл түүхгүй байх:
 - (i) мэдрэлийн эрхтэн тогтолцооны аливаа бүрэлдэхүүн хэсгийн өвчин, эсхүл эмгэг;
 - (ii) мигрень /толгой таллаж өвдөх/, эсхүл бусад хүнд хэлбэрийн толгойн өвчин;
 - (iii) сэтгэхүйн, эсхүл үйл хөдлөлийн хэвийн бус байдал;
 - (iv) сэтгэцийн өөрчлөлтийн нөхцөл;
 - (v) солиорол;
 - (vi) зан чанарын эмгэг;
 - (vii) сэтгэцийн хэвийн бус байдал, эсхүл невроз;
 - (viii) сэтгэл гутрал;
 - (ix) бэртлийн дараах стрессийн эмгэг;
 - (x) мэдрэлийн мэс засал, эсхүл тархины гэмтлийн үр дагавар;
- (3) энэ зүйлийн (c)(1)–ээр хязгаарлахгүйгээр, татаж унадаг өвчний, эсхүл түүнээс үүдэлтэй таталт өгдөг эрсдэл ихэссэнтэй холбоотой бусад нөхцөлийн онош, эсхүл түүхгүй байх;
- (4) аливаа холбогдох ерөнхий чиглэлийн хувьд, 2–р ангиллын ЭМГ-д хамаарах эрхийг аюулгүй хэрэгжүүлэх, эсхүл тухайн ажил үүргийг аюулгүй гүйцэтгэхэд нөлөөлж байгаа, эсхүл нөлөөлж болзошгүй сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэсэн онош, эсхүл өвчний түүхгүй байх;
- (5) аливаа холбогдох ерөнхий чиглэлийн хувьд, 2–р ангиллын ЭМГ-д хамаарах эрхийг аюулгүй хэрэгжүүлэх, эсхүл тухайн ажил үүргийг аюулгүй гүйцэтгэхэд нөлөөлж байгаа, эсхүл нөлөөлж болзошгүй сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэдэггүй байх.

Зүрх судасны эрхтэн тогтолцоо

(d) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах зүрх судасны, эсхүл цусны эргэлтийн эрхтэн тогтолцооны аливаа нөхцөлийн онош, эсхүл түүхгүй байх;
- (2) энэ зүйлийн (d)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн аливаа онош, эсхүл түүхгүй байх:
 - (i) зүрхний титэм судасны өвчин;
 - (ii) зүүн багцын салааны хориг;
 - (iii) ишемигийн шалтгааныг арилгаснаас бусад, баруун багцын салааны хориг;
 - (iv) цусны даралт тогтворгүй ихсэх;
 - (v) зүрхний булчингийн, хавхлагын, эсхүл дамжуулах тогтолцооны хэвийн бус байдал;
 - (vi) зүрхний хэмнэлийн хэвийн бус байдал;
- (3) энэ хэсгийн (d)(1)-ээр хязгаарлахгүйгээр, зүрхний электрон төхөөрөмж шаарддаг эмгэггүй байх;
- (4) зүрхний булчингийн перфузийн үйл ажиллагаанаас бусад, зүрх судасны өвчний эрсдэлт хүчин зүйлгүй байх.

Амьсгалын эрхтэн тогтолцоо

(e) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах амьсгалын замын эрхтэн тогтолцооны аливаа нөхцөлийн онош, эсхүл түүхгүй байх;
- (2) энэ зүйлийн (e)(1)-ээр хязгаарлахгүйгээр, тогтмол хяналтад байдгаас бусад тохиолдолд, НЭМОШ-д хүргэж болох гуурсан хоолойн багтраа өвчний онош, эсхүл түүхгүй байх.

Хоол боловсруулах болон дотоод шүүрлийн булчирхайн эрхтэн тогтолцоо

(f) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах хоол боловсруулах болон дотоод шүүрлийн булчирхайн эрхтэн тогтолцооны аливаа нөхцөлийн онош, эсхүл түүхгүй байх;
- (2) энэ зүйлийн (f)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн аливаа онош, эсхүл түүхгүй байх:
 - (i) хоол боловсруулах эрхтэн, эсхүл түүний дайвар эрхтний хэвийн бус байдал, өвчин, эсхүл эмгэг явц;
 - (ii) хоол боловсруулах эрхтэн, эсхүл түүний дайвар эрхтний өвчин, эсхүл бэртэл, эсхүл мэс заслын үр дагавар;
 - (iii) энэ хэсгийн (3)-т зааснаас бусад, бодисын солилцоо, хоол тэжээл, эсхүл дотоод шүүрлийн булчирхайн эмгэг;
- (3) энэ зүйлийн (f)(1)-ээр хязгаарлахгүйгээр, дараахаас бусад тохиолдолд, чихрийн шижин, эсхүл хэвийн бус глюкозын ямар ч шинж тэмдгийн онош, эсхүл түүхгүй байх:

- (i) тухайн нөхцөл байдал нь чихрийн шижингийн эсрэг аливаа эмийн бодис хэрэглэхгүйгээр, хангалттай түвшинд хянагддаг; эсхүл
- (ii) хэрэв чихрийн шижингийн эсрэг эмийн бодис хэрэглэдэг бол:
 - (iia) тухайн нөхцөл байдал нь эмчийн тогтмол үзлэг, хяналтад байх;
 - (iib) инсулин хэрэглэдэггүй байх;
 - (iic) аливаа холбогдох ерөнхий чиглэлийн хувьд, уудаг эмийг дангаар болон хавсран хэрэглэх нь 2-р ангиллын ЭМГ-нд хамаарах эрх, үүргээ аюулгүй хэрэгжүүлэхэд нөлөөлөхгүй болон бараг нөлөөлөхгүй байх.

Цус болон дархлааны эрхтэн тогтолцоо

(g) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах цус болон дархлааны эрхтэн тогтолцооны аливаа нөхцөлийн онош, эсхүл түүхгүй байх;
- (2) энэ зүйлийн (g)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн аливаа онош, эсхүл түүхгүй байх:
 - (i) цус төлжүүлэлт /миелопролифератив/ болон халдварын шалтгааныг арилгаснаас бусад, дэлүү томрох;
 - (ii) тодорхой хэсгийн, эсхүл бүх биеийн тунгалгийн булчирхай томрох;
 - (iii) цусны өвчин, эсхүл цус, эсхүл түүний бүрдэл хэсгийн өвчний нөхцөл байдал;
 - (iv) дархлаа сулрах, эсхүл хэт идэвхжихтэй холбоотой эмгэг, эсхүл нөхцөл байдал.

Шээс - бэлгийн замын эрхтэн тогтолцоо

(h) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах шээс-бэлгийн замын эрхтэн тогтолцооны аливаа нөхцөлийн онош, эсхүл түүхгүй байх;
- (2) энэ зүйлийн (h)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн аливаа онош, эсхүл түүхгүй байх:
 - (i) шээс-бэлгийн замын эрхтэн тогтолцооны хэвийн бус байдал, эсхүл өвчин;
 - (ii) шээс-бэлгийн замын өвчлөл, эсхүл бэртэл, эсхүл мэс заслын үр дагавар;
 - (iii) бөөр, эсхүл шээсний зам бөглөрсөн, эсхүл бөглөрөх эрсдэл ихэссэн.

Нөхөн үржихүйн эрхтэн тогтолцоо

(i) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах нөхөн үржихүйн эрхтэн тогтолцооны аливаа нөхцөлийн онош, эсхүл түүхгүй байх;
- (2) энэ зүйлийн (i)(1)-ээр хязгаарлахгүйгээр, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн хувьд, НЭМОШ-д хүргэж болох аливаа онош, эсхүл түүхгүй байх:
 - (i) сарын тэмдгийн мөчлөгийн алдагдал;
 - (ii) жирэмслэлт.

Яс – булчингийн эрхтэн тогтолцоо

(j) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах яс–булчингийн эрхтэн тогтолцооны аливаа нөхцөлийн онош, эсхүл түүхгүй байх;
- (2) энэ зүйлийн (j)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн аливаа онош, эсхүл түүхгүй байх:
 - (i) арьс, холбогч эд, яс, үе мөч, булчин, шөрмөс эсхүл булчин-шөрмөсний хэвийн бус байдал, өвчин, эсхүл эмгэг явц;
 - (ii) арьс, холбогч эд, яс, үе мөч, булчин, шөрмөс эсхүл булчин шөрмөсний өвчин, эсхүл бэртэл, эсхүл мэс заслын үр дагавар.

Чих, хамар, хоолойн эрхтэн тогтолцоо

(k) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах чих, хамар, хоолойн эрхтэн тогтолцооны аливаа нөхцөлийн онош, эсхүл түүхгүй байх;
- (2) энэ зүйлийн (k)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн аливаа онош, эсхүл түүхгүй байх:
 - (i) гадна, дунд, эсхүл дотор чихний хэвийн бус байдал, өвчин, эсхүл эмгэг явц;
 - (ii) шүд, ам, эсхүл амьсгалын дээд замын хэвийн бус байдал, өвчин, эсхүл эмгэг явц;
 - (iii) евстахиевийн сувгийн битүүрэл, эсхүл дунд чихний хэвийн бус байдал;
 - (iv) тэнцвэрийн эрхтэн тогтолцооны хэвийн бус байдал.

Сонсгол

(l) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах аливаа сонсголын эмгэгийн онош, эсхүл түүхгүй байх;
- (2) энэ зүйлийн (l)(1)-ээр хязгаарлахгүйгээр, дуу хоолойн тестэд аль ч чихний сонсох чадварын дутагдал илрээгүй, эсхүл дараахаас хэтрээгүй байх:
 - (i) 500, 1000, 2000 Гц-ийн давтамж тус бүрт 35 дБ; эсхүл
 - (ii) НЭМОШ-д хүргэж болох 3000 Гц-ийн давтамжид 50 дБ.

Хараа

(m) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах аливаа сонсголын эмгэгийн онош, эсхүл түүхгүй байх;
- (2) энэ зүйлийн (m)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн аливаа онош, эсхүл түүхгүй байх:
 - (i) нүд, эсхүл түүний дайврын хэвийн бус байдал, өвчин, эсхүл эмгэг явц;
 - (ii) нүд, эсхүл түүний дайврын өвчин, эсхүл бэртэл, эсхүл мэс заслын үр дагавар;
 - (iii) харааны талбайн, эсхүл хос харааны үзүүлэлтүүдийн хэвийн бус байдал;
 - (iv) мэс заслаас үүдэлтэй аль нэг нүдний харааны хугарлын өөрчлөлт;
- (3) энэ зүйлийн (m)(1)-ээр хязгаарлахгүйгээр, холын хараа нь хоёр нүдэнд тус тусдаа шилтэй, эсхүл шилгүй 6/12, эсхүл илүү харах болон хос хараа нь 6/9, эсхүл илүү харах;
- (4) энэ зүйлийн (m)(1)-ээр хязгаарлахгүйгээр, ойрын хараа нь шилтэй, эсхүл шилгүйгээр N5-ын дүрсийг, эсхүл хос хараагаар 30-50 см-ийн хоорондох зайнаас илүү харах;
- (5) энэ зүйлийн (m)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох өнгө ялгах чадварын дутагдал илрээгүй байх.

67.107 3-р ангиллын Эрүүл мэндийн гэрчилгээ

(a) Энэ зүйлийн (b)–ээс (m)-д заасан стандартыг хангаж буй хүсэлт гаргагчийг 3 –р ангиллын ЭМГ-ний стандартыг хангасанд тооцно.

Ерөнхий шаардлага

(b) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах эрүүл мэндийн нөхцөлгүй байх;
- (2) энэ зүйлийн (b)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн аливаа онош, эсхүл түүхгүй байх:

- (i) хэвийн бус байдал;
 - (ii) хөгжлийн бэрхшээлтэй, эсхүл өвчтэй (идэвхтэй, эсхүл нуугдмал);
 - (iii) осол, гэмтэл, эсхүл мэс заслын үр дагавар;
 - (iv) физиологийн, эсхүл эмгэг зүйн явц;
 - (v) хорт хавдрын явц;
 - (vi) ядаргаа үүсгэх нөхцөл;
 - (vii) тохирох эмчилгээ, эсхүл эмчилгээний арга, эсхүл аль аль нь тодорхойгоос бусад халдвар;
- (3) аливаа холбогдох ерөнхий чиглэлийн хувьд, 3–р ангиллын ЭМГ-д хамаарах эрхийг аюулгүй хэрэгжүүлэх, эсхүл тухайн ажил үүргийг аюулгүй гүйцэтгэхэд нөлөөлж байгаа, эсхүл нөлөөлж болзошгүй дараах нөхцөлгүй байх:
- (i) аливаа эм, эмийн бодис, эмийн бэлдмэл хэрэглэдэг, эсхүл тухайн цаг хугацаанд эмчилгээнд бэлдэж байгаа, эсхүл хийлгэж байгаа; эсхүл
 - (ii) аливаа эм, эмийн бодис, эмийн бэлдмэл, эсхүл эмчилгээний бэлтгэл, эсхүл эмчилгээнээс үүдэлтэй аливаа гаж нөлөөнд орсон.

Мэдрэлийн эрхтэн тогтолцоо

(с) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах аливаа мэдрэлийн, мэдрэлийн мэс заслын, сэтгэцийн, эсхүл сэтгэл зүйн нөхцөлийн, эсхүл зан төлөвийн, эсхүл танин мэдэхүйн эмгэгийн онош, эсхүл түүхгүй байх;
- (2) энэ зүйлийн (с)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн аливаа онош, эсхүл түүхгүй байх:
 - (i) мэдрэлийн эрхтэн тогтолцооны аливаа бүрэлдэхүүн хэсгийн өвчин, эсхүл эмгэг;
 - (ii) мигрень /толгой таллаж өвдөх/, эсхүл бусад хүнд хэлбэрийн толгойн өвчин;
 - (iii) сэтгэхүйн, эсхүл үйл хөдлөлийн хэвийн бус байдал;
 - (iv) сэтгэцийн өөрчлөлтийн нөхцөл;
 - (v) солиорол;
 - (vi) зан чанарын эмгэг;
 - (vii) сэтгэцийн хэвийн бус байдал, эсхүл невроз;
 - (viii) сэтгэл гутрал;
 - (ix) бэртлийн дараах стрессийн эмгэг;
 - (x) мэдрэлийн мэс засал, эсхүл тархины гэмтлийн үр дагавар;

- (3) энэ зүйлийн (c)(1)–ээр хязгаарлахгүйгээр, татаж унадаг өвчний, эсхүл түүнээс үүдэлтэй таталт өгдөг эрсдэл ихэссэнтэй холбоотой бусад нөхцөлийн онош, эсхүл түүхгүй байх;
- (4) аливаа холбогдох ерөнхий чиглэлийн хувьд, 3–р ангиллын ЭМГ-д хамаарах эрхийг аюулгүй хэрэгжүүлэх, эсхүл тухайн ажил үүргийг аюулгүй гүйцэтгэхэд нөлөөлж байгаа, эсхүл нөлөөлж болзошгүй сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэсэн онош, эсхүл өвчний түүхгүй байх;
- (5) аливаа холбогдох ерөнхий чиглэлийн хувьд, 3–р ангиллын ЭМГ-д хамаарах эрхийг аюулгүй хэрэгжүүлэх, эсхүл тухайн ажил үүргийг аюулгүй гүйцэтгэхэд нөлөөлж байгаа, эсхүл нөлөөлж болзошгүй сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэдэггүй байх.

Зүрх судасны эрхтэн тогтолцоо

(d) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах зүрх судасны, эсхүл цусны эргэлтийн эрхтэн тогтолцооны аливаа нөхцөлийн онош, эсхүл түүхгүй байх;
- (2) энэ зүйлийн (d)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн аливаа онош, эсхүл түүхгүй байх:
 - (i) зүрхний титэм судасны өвчин;
 - (ii) зүүн багцын салааны хориг;
 - (iii) ишемигийн шалтгааныг арилгаснаас бусад, баруун багцын салааны хориг;
 - (iv) цусны даралт тогтворгүй ихсэх;
 - (v) зүрхний булчингийн, хавхлагын, эсхүл дамжуулах тогтолцооны хэвийн бус байдал;
 - (vi) зүрхний хэмнэлийн хэвийн бус байдал;
- (3) энэ зүйлийн (d)(1)-ээр хязгаарлахгүйгээр, зүрхний электрон төхөөрөмж шаарддаг эмгэггүй байх;
- (4) зүрхний булчингийн перфузийн үйл ажиллагаанаас бусад, зүрх судасны өвчний эрсдэлт хүчин зүйлгүй байх.

Амьсгалын замын эрхтэн тогтолцоо

(e) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах амьсгалын замын эрхтэн тогтолцооны аливаа нөхцөлийн онош, эсхүл түүхгүй байх;
- (2) энэ зүйлийн (e)(1)-ээр хязгаарлахгүйгээр, зөвхөн урьдчилан сэргийлэх зорилгоор кортикостероид эмчилгээ хэрэглэдэг, тогтмол хяналтад байдгаас бусад тохиолдолд, НЭМОШ-д хүргэж болох гуурсан хоолойн багтраа өвчний онош, эсхүл түүхгүй байх.

Хоол боловсруулах болон дотоод шүүрлийн булчирхайн эрхтэн тогтолцоо

(f) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах хоол боловсруулах болон дотоод шүүрлийн булчирхайн эрхтэн тогтолцооны аливаа нөхцөлийн онош, эсхүл түүхгүй байх;
- (2) энэ зүйлийн (f)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн аливаа онош, эсхүл түүхгүй байх:
 - (i) хоол боловсруулах эрхтэн, эсхүл түүний дайвар эрхтний хэвийн бус байдал, өвчин, эсхүл эмгэг явц;
 - (ii) хоол боловсруулах эрхтэн, эсхүл түүний дайвар эрхтний өвчин, эсхүл бэртэл, эсхүл мэс заслын үр дагавар;
 - (iii) энэ хэсгийн (3)-т зааснаас бусад, бодисын солилцоо, хоол тэжээл, эсхүл дотоод шүүрлийн булчирхайн эмгэг;
- (3) энэ зүйлийн (f)(1)-ээр хязгаарлахгүйгээр, дараахаас бусад тохиолдолд, чихрийн шижин, эсхүл хэвийн бус глюкозын ямар ч шинж тэмдгийн онош, эсхүл түүхгүй байх:
 - (i) чихрийн шижингийн эсрэг аливаа эмийн бодис хэрэглэхгүйгээр, тухайн нөхцөл байдлыг хангалттай түвшинд хянадаг бол; эсхүл
 - (ii) хэрэв тухайн нөхцөл байдлыг хянахын тулд чихрийн шижингийн эсрэг эмийн бодис хэрэглэдэг бол:
 - (iia) нөхцөл байдал нь эмчийн тогтмол үзлэг, хяналтад байх;
 - (iib) инсулин хэрэглэдэггүй байх;
 - (iic) аливаа холбогдох ерөнхий чиглэлийн хувьд, уудаг эмийн бодис дангаар болон хавсран хэрэглэх нь 3-р ангиллын ЭМГ-нд хамаарах эрх, үүргээ аюулгүй хэрэгжүүлэхэд нөлөөлөхгүй болон бараг нөлөөлөхгүй байх.

Цус болон дархлааны эрхтэн тогтолцоо

(g) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах цус болон дархлааны эрхтэн тогтолцооны аливаа нөхцөлийн онош, эсхүл түүхгүй байх;
- (2) энэ зүйлийн (g)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн аливаа онош, эсхүл түүхгүй байх:
 - (i) цус төлжүүлэлт /миелопролифератив/ болон халдварын шалтгааныг арилгаснаас бусад, дэлүү томрох;
 - (ii) тодорхой хэсгийн, эсхүл бүх биеийн тунгалгийн булчирхай томрох;
 - (iii) цусны өвчин, эсхүл цус, эсхүл түүний бүрдэл хэсгийн өвчний нөхцөл байдал;

- (iv) дархлаа сулрах, эсхүл хэт идэвхжихтэй холбоотой эмгэг, эсхүл нөхцөл байдал.

Шээс - бэлгийн замын эрхтэн тогтолцоо

(h) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах шээс-бэлгийн замын эрхтэн тогтолцооны аливаа нөхцөлийн онош, эсхүл түүхгүй байх;
- (2) энэ зүйлийн (h)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн аливаа онош, эсхүл түүхгүй байх:
 - (i) шээс-бэлгийн замын эрхтэн тогтолцооны хэвийн бус байдал, эсхүл өвчин;
 - (ii) шээс-бэлгийн замын өвчлөл, эсхүл бэртэл, эсхүл мэс заслын үр дагавар;
 - (iii) бөөр, эсхүл шээсний зам бөглөрсөн, эсхүл бөглөрөх эрсдэл ихэссэн.

Нөхөн үржихүйн эрхтэн тогтолцоо

(i) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах нөхөн үржихүйн эрхтэн тогтолцооны аливаа нөхцөлийн онош, эсхүл түүхгүй байх;
- (2) энэ зүйлийн (i)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн аливаа онош, эсхүл түүхгүй байх:
 - (i) сарын тэмдгийн мөчлөгийн алдагдал;
 - (ii) жирэмслэлт.

Яс – булчингийн эрхтэн тогтолцоо

(j) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах яс–булчингийн эрхтэн тогтолцооны аливаа нөхцөлийн онош, эсхүл түүхгүй байх;
- (2) энэ зүйлийн (j)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн аливаа онош, эсхүл түүхгүй байх:
 - (i) арьс, холбогч эд, яс, үе мөч, булчин, шөрмөс эсхүл булчин-шөрмөсний хэвийн бус байдал, өвчин, эсхүл эмгэг явц;
 - (ii) арьс, холбогч эд, яс, үе мөч, булчин, шөрмөс эсхүл булчин шөрмөсний өвчин, эсхүл бэртэл, эсхүл мэс заслын үр дагавар.

Чих, хамар, хоолойн эрхтэн тогтолцоо

(k) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах чих, хамар, хоолойн эрхтэн тогтолцооны аливаа нөхцөлийн онош, эсхүл түүхгүй байх;
- (2) энэ зүйлийн (к)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн аливаа онош, эсхүл түүхгүй байх:
 - (i) гадна, дунд, эсхүл дотор чихний хэвийн бус байдал, өвчин, эсхүл эмгэг явц;
 - (ii) шүд, ам, эсхүл амьсгалын дээд замын хэвийн бус байдал, өвчин, эсхүл эмгэг явц;
 - (iii) тэнцвэрийн эрхтэн тогтолцооны хэвийн бус байдал.

Сонсгол

(l) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах аливаа сонсголын эмгэгийн онош, эсхүл түүхгүй байх;
- (2) энэ зүйлийн (l)(1)-ээр хязгаарлахгүйгээр, аль ч чихний сонсох чадварын дутагдал нь дараахаас хэтрээгүй онош, эсхүл түүхгүй байх:
 - (i) 500, 1000, 2000 Гц-ийн давтамж тус бүрт 35 дБ; эсхүл
 - (ii) НЭМОШ-д хүргэж болох 3000 Гц-ийн давтамжид 50 дБ.

Хараа

(m) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах аливаа харааны эмгэгийн онош, эсхүл түүхгүй байх;
- (2) энэ зүйлийн (m)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн аливаа онош, эсхүл түүхгүй байх:
 - (i) нүд, эсхүл түүний дайврын хэвийн бус байдал, өвчин, эсхүл эмгэг явц;
 - (ii) нүд, эсхүл түүний дайврын өвчин, эсхүл бэртэл, эсхүл мэс заслын үр дагавар;
 - (iii) харааны талбайн, эсхүл хос харааны үзүүлэлтийн хэвийн бус байдал;
 - (iv) мэс заслаас үүдэлтэй аль нэг нүдний харааны хугарлын өөрчлөлт;
- (3) энэ зүйлийн (m)(1)-ээр хязгаарлахгүйгээр, холын хараа нь хоёр нүдэнд тус тусдаа шилтэй, эсхүл шилгүй 6/9, эсхүл илүү харах болон хос хараа нь 6/6, эсхүл илүү харах;
- (4) энэ зүйлийн (m)(1)-ээр хязгаарлахгүйгээр, ойрын хараа нь шилтэй, эсхүл шилгүйгээр N5-ын дүрсийг, эсхүл хос хараагаар 30-50 см-ийн хоорондох зайнаас илүү харах болон дундын хараа нь N14 дүрсийг, эсхүл хос хараагаар 1 м-ийн зайнаас илүү харах;

- (5) энэ зүйлийн (m)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох өнгө ялгах чадварын дутагдал илрээгүй байх.

D Бүлэг – Эрүүл мэндийн шалгагч

67.151 Зорилго

Энэ Бүлэг нь дараах шаардлагыг тогтооно:

- (1) ЭМШ-ийг томилох;
- (2) ИНЕГ-ын үндсэн ажилтан бус зохих ёсоор мэргэшсэн ЭМШ-ийг томилох.

67.153 Эрүүл мэндийн шалгагчийн гэрчилгээ

Дарга, энэ дүрмийн дагуу дараах ЭМШ-ийн гэрчилгээ олгож болно:

- (1) ЭМШ -1 Гэрчилгээ;
- (2) ЭМШ - 2 Гэрчилгээ;
- (3) ЭМШ -Тусгай Гэрчилгээ.

67.155 Гэрчилгээ эзэмших хүсэлт

(a) ЭМШ-ийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч этгээд нь Даргын шаардсан холбогдох маягтыг бөглөж, дараах баримтын хамт хүргүүлэх үүрэгтэй:

- (1) 67.163-т шаардсан Ерөнхий заавар;
- (2) зохих төлбөрийн баримт.

(b) ЭМШ-ийн гэрчилгээ сунгуулах хүсэлт гаргагч нь Даргын шаардсан холбогдох маягтыг бөглөж, зохих төлбөрийн баримтын хамт гэрчилгээнд заасан сунгуулах хугацаанаас 30-аас доошгүй хоногийн өмнө, эсхүл хэрэв ийм хугацаа заагаагүй бол, гэрчилгээний хүчинтэй хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө Даргад хүргүүлэх үүрэгтэй.

67.157 Эрүүл мэндийн шалгагчийн гэрчилгээ олгох

(a) Энэ дүрмийн хэрэгжилтийг харгалзан, Дарга, энэ дүрмийн 67.161-ийн шаардлагыг хангасан хүсэлт гаргагчид ЭМШ-ийн гэрчилгээ олгоно.

(b) Энэ зүйлийн (a)-г үл харгалзан, Дарга анхаарах шаардлагатай гэж үзсэн аливаа нөхцөлд, энэ дүрмийн 67.161-т заасан шаардлага хангаагүй этгээдэд ЭМШ - Тусгай Гэрчилгээ олгож болно, хэрэв:

- (1) тухайн этгээд нь мэргэжлээрээ ажиллаж байгаа эмч бол;

- (2) Дарга, тухайн этгээдэд ЭМШ - Тусгай Гэрчилгээ олгох онцгой нөхцөл, эсхүл газарзүйн нөхцөл байдлаас шалтгаалсан, эсхүл үйл ажиллагааны тусгай нөхцөл байдал үүссэн гэж үзвэл.

67.159 Эрүүл мэндийн шалгагчийн гэрчилгээ эзэмшигчийн эрх

Дараах хүчинтэй гэрчилгээ эзэмшдэг этгээд нь:

- (1) ЭМШ-1 Гэрчилгээ - аливаа ангиллын ЭМГ олгох зорилгоор эрүүл мэндийн үзлэг хийх;
- (2) ЭМШ-2 Гэрчилгээ - 2-р ангиллын ЭМГ олгох зорилгоор эрүүл мэндийн үзлэг хийх;
- (3) ЭМШ-Тусгай Гэрчилгээ - Даргын бичгээр өгсөн чиглэлийн дагуу ЭМГ олгох зорилгоор эрүүл мэндийн үзлэг хийж болно.

67.161 Эрүүл мэндийн шалгагчийн гэрчилгээжүүлэлтийн шаардлага

ЭМШ-ийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах тохиолдолд, ЭМШ-ийн гэрчилгээнд тавих шаардлагыг хангана, хэрэв тухайн этгээд нь:

- (1) мэргэжлээрээ ажиллаж байгаа эмч бол;
- (2) дараах шаардлагыг хангасан бол:
 - (i) Даргын хүлээн зөвшөөрөхүйц нисэхийн анагаах ухааны сургалтыг амжилттай төгссөн;
 - (ii) Даргын хүлээн зөвшөөрөхүйц нисэхийн анагаах ухааны зохицуулалтын сургалтыг амжилттай төгссөн;
 - (iii) энэ дүрмийн Хавсралт А–д заасан холбогдох ур чадварыг хангаж байгаагаа Даргад батлан харуулсан,
- (3) эрүүл мэндийн үзлэгийг, Эрүүл мэндийн зааварт шаардсан стандартын дагуу хийх зорилгоор, зориулалтын эмчилгээний, захиргааны болон холбогдох байгууламжид нэвтрэх эрхтэй бол;
- (4) анагаахын англи хэлээр үр дүнтэй харилцах чадвартай бол;
- (5) 67.163-т заасан Ерөнхий зааврын шаардлагыг хангасан бол.

67.163 Ерөнхий заавар

(а) ЭМШ-ийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргаж буй этгээд нь дараахийг багтаасан Ерөнхий зааврыг Даргад ирүүлэх үүрэгтэй:

- (1) Ерөнхий заавар нь дараах шаардлагыг хангаж байгааг бататгаж тухайн этгээд гарын үсэг зурсан мэдэгдэл:
 - (i) тухайн этгээдийн нисэхийн эрүүл мэндийн үйл ажиллагааг нягт нямбай тодорхойлж, тухайн этгээд 67.161–ийн байнгын хэрэгжилтийг бататгах арга хэлбэр болон аргачлалыг тодорхой харуулсныг;

- (ii) тухайн этгээд болон түүнтэй нисэхийн эрүүл мэндийн үйл ажиллагаанд оролцож байгаа аливаа эмнэлгийн ажилтнууд байнга дагаж мөрдөхийг;
- (2) тухайн этгээдийн нисэхийн эрүүл мэндийн үйл ажиллагааны цар хүрээний тодорхойлолт;
- (3) тухайн этгээдийн, нисэхийн эрүүл мэндийн үйл ажиллагаанд оролцож байгаа ажилтнуудын албан тушаал, овог нэр;
- (4) энэ хэсгийн (3)-д заасан ажилтнуудын үүрэг ба хариуцлага;
- (5) тухайн этгээдийн, нисэхийн анагаахын үйл ажиллагаа эрхлэх байрлалын жагсаалт;
- (6) тухайн этгээд, эрүүл мэндийн үзлэгийг, Эрүүл мэндийн зааварт шаардсан стандартын дагуу хийх зорилгоор, зориулалтын эмчилгээний, захиргааны болон холбогдох байгууламжид нэвтрэх эрхтэй болохыг харуулсан дэлгэрэнгүй мэдээлэл;
- (7) дараахийг багтаасан Даргатай харилцах журам:
 - (i) Даргаар дүгнэлт гаргуулахаар ЭМГ эзэмших хүсэлтийг хүргүүлэх;
 - (ii) хамааралтай бол, ЭМГ эзэмшдэг этгээдийн эрүүл мэндийн нөхцөлийн аливаа өөрчлөлт, эсхүл тухайн этгээдийн ЭМГ-д хамаарах эрхээ аюулгүй хэрэгжүүлэхэд нөлөөлж болох, өмнө нь илэрч байгаагүй эрүүл мэндийн нөхцөл үүссэн талаар мэдээлэх;
 - (iii) энэ зүйлийн (a)(2), (3), (4), эсхүл (5)-д заасан мэдээллийн санал болгож буй өөрчлөлтийн талаар урьдчилан мэдэгдэх;
- (8) тухайн этгээдийн 67.203-т заасан шаардлагыг байнга дагаж мөрдөхийг бататгах арга хэлбэрийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;
- (9) дараахийг зохих ёсоор гүйцэтгэх тогтолцоо болон журмын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл:
 - (i) эмнэлгийн тоног төхөөрөмжийн хяналт, үзлэг шалгалт, тест хийх болон тохируулга хийх;
 - (ii) тухайн этгээдийн, нисэхийн эрүүл мэндийн үйл ажиллагаатай холбоотой бичиг баримтын өөрчлөлт болон хяналт;
 - (iii) бүртгэлийг ялгаж тодорхойлох, цуглуулах, индексжүүлэх, хадгалах, засварлах болон устгах;
 - (iv) (9)(i), (9)(ii) болон (9)(iii)-т заасан ажил үүргийг гүйцэтгэх аливаа ажилтныг сургах, үнэлэх болон эрх олгох;
- (10) тухайн этгээдийн мэргэжлийн ажил үүргээс үүдэлтэй ашиг сонирхлын зөрчилдөөнийг тодорхойлох, удирдах журмын нарийвчилсан мэдээлэл;
- (11) тухайн этгээдийн, нисэхийн эрүүл мэндийн үйл ажиллагаа Ерөнхий зааврын дагуу явагдаж байгааг бататгах тухайн жилийн чанарын дотоод хяналтын хөтөлбөрийн дэлгэрэнгүй;
- (12) дараах журмын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл:

- (i) Ерөнхий зааварт хяналт тавих, өөрчлөлт оруулах;
 - (ii) энэ Дүрмийн холбогдох шаардлагад нийцэж байгааг бататгах;
 - (iii) Ерөнхий зааварт нэмэлт өөрчлөлт оруулсны дараа нэмэлт, өөрчлөлт бүрийн хувийг Даргад нэн даруй хүргүүлэхийг бататгах;
 - (iv) Ерөнхий зааврын хувийг ажилтнуудад хүргүүлэх.
- (b) Тухайн этгээдийн Ерөнхий заавар нь Дарга хүлээн зөвшөөрөхүйц байна.

Е Бүлэг – Эрүүл мэндийн шалгагчийн үйл ажиллагааны шаардлага

67.201 Зорилго

Энэ Бүлэг нь, ЭМШ-ийн үйл ажиллагаатай холбоотой шаардлагыг тогтооно.

67.203 Байнгын хэрэгжүүлэлт

- (a) ЭМШ-ийн гэрчилгээ эзэмшдэг аливаа этгээд нь дараах үүрэгтэй:
- (1) Ерөнхий зааварт заагдсан үзлэгийн байр бүрд, Ерөнхий зааврын нэгээс доошгүй хүчинтэй, бүрэн хувийг хадгалах;
 - (2) Ерөнхий зааварт дэлгэрэнгүй заагдсан бүх журам, тогтолцоо болон хөтөлбөрийг дагаж мөрдөх (ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой журмыг багтаасан байна);
 - (3) Ерөнхий зааврын холбогдох бүлгүүдийг шаардлагатай ажилтнууд ажил үүргээ гүйцэтгэхдээ байнга ашиглахад боломжтой байлгах;
 - (4) D Бүлэгт заасан ЭМШ-ийн гэрчилгээнд хамаарах бүх шаардлагыг байнга хангах;
 - (5) Даргын шаардаж болох, нисэхийн анагаахын болон нисэхийн зохицуулалтын дүрэм, журмын сургалтын курсэд тогтмол хамрагдах;
 - (6) Даргын гаргасан ерөнхий чиглэл болон яаралтай удирдамжийг дагаж мөрдөх;
 - (7) эрүүл мэндийн зааврын хамгийн сүүлчийн, шинэчлэгдсэн хувийг хадгалах;
 - (8) ЭМГ эзэмших хүсэлт гаргагч бүрийн үзлэг бүрийн бүрэн гүйцэд бүртгэлийг хадгалж байгааг бататгах;
 - (9) холбогдох утас, факс, хаягт өөрчлөлт орсон тохиолдолд тухайн өөрчлөлтийн талаарх мэдээллийг өөрчлөлт орсон өдрөөс хойш 28 хоногийн дотор Даргад мэдэгдэх.
- (b) Дарга, 67.163 (a)(7)(iii)-т заасан аливаа өөрчлөлтийг оруулах үед, эсхүл өөрчлөлтийн дараа ЭМШ-ийн гэрчилгээ эзэмшдэг этгээдийн ажиллах нөхцөлийг тогтоож болно.
- (c) ЭМШ-ийн гэрчилгээ эзэмшдэг этгээд нь дараах үүрэгтэй:

- (1) энэ зүйлийн (b)-д заасан аливаа нөхцөлийг дагаж мөрдөх;
- (2) энэ зүйлийн (b)-д, тодорхойлсон аливаа өөрчлөлт нь ЭМШ-ийн гэрчилгээнд өөрчлөлт оруулахыг шаардсан тохиолдолд гэрчилгээг Даргад нэн даруй хүргүүлэх;
- (3) нисэхийн аюулгүй ажиллагааны ашиг сонирхлын үүднээс Дарга анхаарах шаардлагатай гэж үзсэн өөрчлөлтийг гэрчилгээ эзэмшигч Ерөнхий заавартаа оруулах.

F Бүлэг – Даргаас эрх шилжүүлэхэд тавих шаардлага

67.251 Зохих ёсоор мэргэшсэн Эрүүл мэндийн шалгагчийг тодорхойлох

Энэ дүрмийн дагуу эрх шилжүүлэх зорилгоор, дараах тохиолдолд тухайн этгээдийг зохих ёсоор мэргэшсэн ЭМШ гэж үзнэ, хэрэв:

- (1) тухайн этгээд нь:
 - (i) ЭМШ-1 Гэрчилгээ эзэмшдэг бол, аливаа ангиллын ЭМГ;
 - (ii) ЭМШ-2 Гэрчилгээ эзэмшдэг бол, 2-р ангиллын ЭМГ,
- (2) Дарга тухайн этгээдийг дараах шаардлага хангасан гэж үзвэл:
 - (i) зайлшгүй шаардлагатай ур чадвар, дадлага туршлагатай;
 - (ii) нисэхийн эрүүл мэндийн гэрчилгээжүүлэлтийн бодлого, журмын талаарх мэдлэгтэй;
- (3) Даргын шаардаж болох, нисэхийн анагаахын болон нисэхийн зохицуулалтын дүрэм, журмын сургалтын курсэд хамрагдсан бол;
- (4) Дарга тухайн этгээдийг ашиг сонирхлын зөрчлийг тодорхойлох журмыг дагаж мөрддөг, шаардлага хангасан гэж үзвэл.

G Бүлэг – Нисэхийн шалгагч - нөөц

H Бүлэг – Шилжилтийн зохицуулалт

67.351 Шилжилтийн зохицуулалт

(a) Энэ зүйлийн (b) болон (c)-г харгалзан, энэ дүрэм хэрэгжиж эхлэхээс өмнө ЭМШ-1 Гэрчилгээ болон ЭМШ-2 Гэрчилгээ шинээр авах, эсхүл сунгах хүсэлтийг шийдвэрлэхдээ Дарга энэ дүрэм болон Шилжилтийн үеийн эрүүл мэндийн шалгуур үзүүлэлтийн дагуу шинээр олгох, эсхүл шинэчлэн сунгаж болно.

(b) Хэрэв энэ зүйлийн (a) хамаарах бол, Дарга газарзүйн байршлыг хамарсан тодорхой хэрэгцээ шаардлагаар гэрчилгээ шинээр олгох, эсхүл сунгахаас бусад тохиолдолд, тухайн хүсэлт гаргагч Шилжилтийн үеийн нисэхийн эрүүл мэндийн

шалгуур үзүүлэлтийн Хавсралт 1-д заасан холбогдох ур чадварын шалгуурыг хангаснаас бусад тохиолдолд ЭМШ-2 Гэрчилгээ шинээр авах, эсхүл сунгуулах хүсэлтийг хүлээн авахгүй.

(с) ЭМШ-ийн гэрчилгээ эзэмшиж буй этгээд нь, дүрэм хүчинтэй болсон өдрөөс хойш 6 сарын дотор, 67.163–ын шаардлагыг бүрэн хангасан Ерөнхий зааврыг Даргад хүргүүлэх үүрэгтэй.

(d) ЭМШ-ийн гэрчилгээ эзэмшиж буй этгээд нь, Ерөнхий зааврыг Даргад хүргүүлсэн байхыг шаардсан өдрийг хүртэл, Ерөнхий заавартай холбоотой Е Бүлэгт тусгагдсан үйл ажиллагааны шаардлагыг дагаж мөрдөх шаардлагагүй.

(e) Дарга, энэ дүрэм хүчинтэй болохоос өмнө хүлээн авсан ЭМГ эзэмших хүсэлтийг хэрэв энэ дүрэм хүчинтэй болохоос өмнө шийдвэрлээгүй бол, тухайн хүсэлтийг хүлээн авах үед хүчинтэй үйлчилж байсан дүрмийн дагуу шийдвэрлэнэ.

Хавсралт А – Эрүүл мэндийн шалгагчийн ур чадвар

Эрүүл мэндийн шалгагчийн гэрчилгээ эзэмшихэд шалгуулах шаардлагатай ур чадвар

ЭМШ-ийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь нэмэлтээр, бусад ерөнхий шаардлагыг хангасан байх, ЭМШ-ийн ажил үүргийг хэвийн гүйцэтгэх хангалттай түвшний ур чадвар, туршлагатай болохоо шалгуулах шаардлагатай. Үндсэн 4 төрлийн ур чадварын ангилал байх ба эдгээрт оношлон илрүүлэх чадвар, үнэлгээ хийх чадвар, менежмент хийх ур чадвар болон аудит үнэлгээ хийх ур чадвар хамаарна.

Тайлбар:

- ЭМШ-2 Гэрчилгээ эзэмшигчийн хувьд, 2-р ангиллын ЭМГ олгох зорилгоор хийх үзлэгтэй холбоотой ур чадвар.
- ЭМШ-1 Гэрчилгээ эзэмшигчийн хувьд, 1, 2 болон 3-р ангиллын ЭМГ олгох зорилгоор хийх үзлэгтэй холбоотой ур чадвар.
- Ур чадварын үзүүлэлт нь дараах 3 түвшинтэй байна:

мэдлэгтэй	зөвхөн тухайн сэдвийн онолын мэдлэг
туршлагатай	тухайн этгээд хяналтан дор ажиллаж чадах бодит практик туршлага
эксперт	тухайн этгээд бие даан ажиллах болон бусдад хяналт тавих чадвартай

Дараах хүснэгтэд ЭМШ-1 Гэрчилгээ болон ЭМШ-2 Гэрчилгээ эзэмшигчид шаардлагатай ур чадвар болон ур чадварын түвшингийн жагсаалтыг үзүүлсэн.

Шаардлагатай ур чадварын тодорхойлолт	Ур чадварын түвшин	
	ЭМШ-1	ЭМШ-2
Оношлон илрүүлэх		
1. Дараах зүйлсийг ашиглан нисэхийн орчинд сөргөөр нөлөөлж болох нөхцөл байдлыг нарийн зөв оношилж үнэлэлт дүгнэлт өгөх эмчилгээний ур чадвар эзэмшсэн: <ul style="list-style-type: none"> • эмчилгээний түүх: • бие махбодын болон сэтгэцийн үзлэг: • нэмэлт шинжилгээ судалгаа, эсхүл мэргэжлийн үнэлгээ өгөх (ЭМШ-аар гүйцэтгүүлэх, эсхүл зохион байгуулах): • оношлох ур чадвар: • хамтран ажиллагсад, бусад эрүүл мэндийн мэргэжилтнүүд болон байгууллагатай хамтран ажиллах. 	эксперт	эксперт
2. Хүсэлт гаргагчийн эрүүл мэндийн нөхцөл, эсхүл нисэхийн үйл ажиллагааны орчинд аюултай үйлдэл хийх шалтгаан болох нөхцөл байдлын хүчин зүйлийг олж тогтоох	эксперт	туршлагатай
3. Эрүүл мэндийн зохицуулалтын аливаа ашиг сонирхлын зөрчил, эсхүл өрсөлдөөнийг илрүүлж, тогтоох	туршлагатай	туршлагатай
4. Хүсэлт гаргагчийг нисэхийн орчинд аюулгүй ажиллаж чадах эсэхийг үнэлж дүгнэх чадвараа сайжруулах зорилгоор нэмэлт эх сурвалжаас мэдээлэл авдаг байх. Жишээ нь сэтгүүл, шинжлэх ухааны судалгааны тайлан, интернетийн эх сурвалж, хамтран ажиллагсад болон тусгай мэргэжлийн зөвлөх, багш зэрэг.	туршлагатай	туршлагатай
Үнэлгээ хийх		
5. Тухайн хүсэлт гаргагчийг нисэхийн орчинд аюулгүй ажиллахад тохиромжтой эсэхийг тодорхойлох болон дүгнэлт хийхдээ баримт нотолгоонд суурилсан анагаахын зарчим, үйл явцыг ашигладаг байх.	эксперт	туршлагатай
6. Нисэхийн орчинд ажиллах хүсэлт гаргагчийн аюулгүй, нийцтэй байдлыг тогтоохтой холбоотой хууль дүрэм, болон эрүүл мэндийн хууль эрх зүйн анхаарах асуудлыг тодорхойлж, дүн шинжилгээ хийдэг байх.	туршлагатай	туршлагатай
7. Нисэхийн орчинд ажиллах хүсэлт гаргагчийн аюулгүй, нийцтэй байдалд үнэлгээ хийх чадвараа сайжруулах зорилгоор нэмэлт мэдээлэл болох мэргэжлийн сэтгүүл, шинжлэх ухааны судалгаа, шинжилгээ, интернетийн эх сурвалж, хамтран ажиллагсад, мэргэжлийн зөвлөгч ашиглах ба шүүмжлэлтэй дүн шинжилгээ хийдэг байх.	туршлагатай	туршлагатай
Менежмент хийх		
8. Шаардлагатай стандарт, арга аргачлал болон процессыг ашиглан нисэхийн орчинд ажиллаж буй хүсэлт гаргагчтай холбоотой эрсдэлд үнэлгээ хийх	эксперт	эксперт
9. зөрчилдөж, эсхүл өрсөлдөж буй ашиг сонирхлыг нисэхийн аюулгүй ажиллагаанд, эсхүл эмчилгээний шийдвэрийн чанарт нөлөөлөхгүй хэлбэрээр зохицуулах	эксперт	туршлагатай

Шаардлагатай ур чадварын тодорхойлолт	Ур чадварын түвшин	
	ЭМШ-I	ЭМШ-II
10. Үр дүнтэй харилцаа холбоо: <ul style="list-style-type: none"> • хүсэлт гаргагч, ИНЕГ, хамтран ажиллагсад болон бусад байгууллагуудад чиглэсэн эрсдэлийн үнэлгээ болон, анхаарах асуудлыг тодорхойлох. • хүсэлт гаргагчтай холбоотой хууль, дүрмийн талаар мэдээлэлтэй байх. • эрсдэлийн удирдлагын зохицуулалтын шийдвэр гаргахад шаардлагатай нэмэлт мэдээлэл, зөвлөмж болон зааварчилгаа авах зорилгоор хамтран ажиллагсад, зөвлөгч болон бусад хүмүүстэй харилцах. 	эксперт	эксперт
11. Бүртгэлийн систем болон захиргааны ажлыг дараах хэлбэрээр зохион байгуулах: <ul style="list-style-type: none"> • зохицуулалтын эрсдэлийн үнэлгээ болон эрсдэлийн удирдлагын шийдвэр, үйлдэл бүрийг найдвартай, нягт нямбай баримтжуулсан байх • зохицуулалтын эрсдэлийн үнэлгээ болон эрсдэлийн удирдлагын шийдвэр нь аливаа хоёрдмол утга агуулгагүй, тодорхой үр дүнд чиглэсэн байх • зохицуулалтын эрсдэлийн үнэлгээ болон эрсдэлийн удирдлагын шийдвэр, үйлдэл нь хэдийд ч буцаан сэргээгдэхээр байх 	эксперт	эксперт
Эргэн шалгах / аудит хийх		
12. Мониторинг хийх, эргэж шалгах болон аудитын үйл ажиллагаанд бүтээлчээр оролцдог байх, үүнд: <ul style="list-style-type: none"> • эргэж шалгах үйл явцад идэвхтэй оролцох • шалгалтаар илэрсэн алдаа дутагдал, үр дүнг бодитоор үнэлж, дүгнэх • аудит шалгалтын зөвлөмжийг хэрэгжүүлэх 	туршлагатай	туршлагатай

--oOo--